



АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2018/09



www.nso.mn www.arkhangai.nso.mn www.1212.mn




ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 519 ор, амбулаторийн 111 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 227,6 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 81,3 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 15,7 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 97,2 хувийг бүрэн хамруулсны дотор Хайрхан, Өлзийт, Хашаат, Цахир сумд 100,0 хувь хамруулсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 9 сарын байдлаар



Оны эхний 9 сард 1302 эх төрж, 1304 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 10,7 хувиар буюу 156 хүүхдээр бага байна,

Хүн амын нас баралт 397 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 57 тохиолдлоор буюу 16,8 хувиар их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 13,7, нас баралт 4,2 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 9,5 промил байна. Төрөхийн улмаас эндсэн эхийн эндэгдэл 1 гарч, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 9, нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 28 гарч мянган

амьд төрөлтөд 21,5 ногдож байна.



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 43 нь буюу 411 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Батцэнгэл(48), Эрдэнэбулган(72), Булган (59), Ихтамир (62), Өндөрүлаан (45), Жаргалант (56) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 13,1 хувь нь салхин цэцгээр, 49,9 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 12,6 хувь нь сүрьеэгээр, 24,4 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Халдварт өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеийнхээс 14,4 хувиар буюу 52 тохиолдлоор нэмэгдсэн байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР


10 дугаар сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 936 ажилгүй хүн байгаагийн 49,4 хувь нь буюу 462 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10,0 мянган хүн тутамд 161 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1,2 хувиар

буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 98,8 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 118 нь дээд, 30 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 726 нь бүрэн болон бүрэн бус дунд, 51 нь бага боловсролтой хүмүүс байна.

9 дүгээр сард ажилгүйчүүдийн бүртгэлд 243 хүн шинээр бүртгүүлж, 113 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж 112 хүн ажилд зуучлуулан орсон байна.

Оны эхний 9 сард аймгийн дүнгээр 803 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган сум 350, Эрдэнэмандал, Өндөрүлаан, Булган, Цэнхэр, Ихтамир, Хангай, Жаргалант, Өлзийт, Чулуут, Хашаат, Тариат сумд 20-70 ажлын байрыг, Хайрхан, Цэцэрлэг, Батцэнгэл сумд 16-17 ажлын байрыг, Хашаат, Өгийнуур, Төвшрүүлэх, Цахир сумд 10-17 ажлын байрыг, ажлын байрыг бий болгожээ. Харин Хотонт сум нэг ч ажлын байр бий болгоогүй байна.

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэний тоо





НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 9 сард 38,4 тэрбум төг, зарлага 37,5 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 2656,0 сая төг буюу 7,4 хувиар, зарлага 2474,9 сая төг буюу 7,1 хувиар өслөө.


Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 2656,0 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 15,0 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 5,4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 7,1 хувиар өсөхөд тэтгэврийн даатгалын сан 14,2 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 6,5 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сан 5,9 хувиар өссөн нь шууд нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 13,1 мянган хүнд 31,8 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 1132 хүнд 1282,9 сая төгрөгийг олгосон байна.

Оны эхний 9 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 20,2 мянган хүнд 10295,2 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 50,2 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт, 49,8 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 54,4 хувийг халамжийн тэтгэврээр, 28,3 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 17,3 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц




ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 242 хүн гэмт хэрэгт холбогдож 384 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 128, өмчлөх эрхийн эсрэг 141, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 30, байгаль хамгаалах журмын эсрэг 16, бусад 69 хэрэг гарсан байна.


Гэмт хэргийн улмаас 14 хүн нас барж, 165 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 803,4 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 9,6 хувийг бүлэглэж 14,6 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 415 хүнийг албадан саатуулж 173 хүнийг баривчилсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 9 сарын байдлаар



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 0,3 хувиар буюу 1 тохиолдлоор нэмэгдсэний дотор хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 3,0 хувиар буюу 4 тохиолдлоор, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 27,7 хувиар буюу 54 тохиолдлоор буурсан байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 9 сарын байдлаар






ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2018 оны эхний 9 сард аймгийн төсөвт 16943,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 18131,7 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 107,0 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 4603,2 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 5790,9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 125,8 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг Төвшрүүлэхээс бусад бүх сумд 101,5 хувиас 5,1 дахин биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Орлогыг нэр төрлөөр нь үзвэл ойгоос хэрэглээний мод түлээ ашигласны төлбөр, түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласны төлбөр, бууны татвараас бусад нэрийн орлогуудыг 106,0 хувиас 4,9 дахин биелүүлсэн байна.


Аймгийн төсвийн орлогын 68,1 хувийг тусламжийн орлогоор, 13,7 хувийг орлогын албан татвараар, 1,3 хувийг өмчийн татвараар, 1,6 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 4,9 хувийг бусад албан татвараар, 3,2

хувийг татварын бус орлогоор, 7,2 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 188,2 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 760,7 сая төгрөг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр 462,4 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 25,3 сая төгрөг бүгд 1436,6 сая төгрөгийг шилжүүлж даалгаврыг 89,5 хувиар давуулан биелүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 45533,5 сая төгрөг байгаагийн 49,0 хувийг цалин хөлсөнд, 5,9 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 45,1 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 39,4 хувийг нийтийн ерөнхий үйлчилгээнд, 50,0 хувийг боловсролын салбарт, 9,6 хувийг эрүүл мэндийн салбарт, 0,6 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0,4 хувийг бусад салбарт зарцууллаа.

Орон нутгийн төсвийн байгууллагын нийт зарлагын бүтэц, хувиар




МОНГО ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 5 банкны салбар иргэд аж

ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 21,0 тэрбум төгрөгийг авч 24,0 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 9 сард банкууд 45,7 мянган иргэд, аж ахуй нэгжид 107,9 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 9 сарын байдлаар сая.төг



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 24,9 хувиар, олгосон зээлийн хэмжээ 8,8 хувиар өсч анхаарал хандуулах зээлийн хэмжээ 26,6 хувиар буурсан байна., Харин чанаргүй зээлийн хэмжээ 29,7 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2018 оны 9 дүгээр сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0,2 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 4,2 хувиар, 2017 оны 12-р сарынхаас 3,8 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 8 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 238 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын

13,4 хувийнх нь өсч, 11,8 хувийнх нь үнэ буурч 74,8 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас үхэр хонины мах, манжин байцаа төмс, шар цагаан будааны үнэ 0,1-26,4 хувиар буурч харин ундаа, үзэм, цай, эрээн даавуу, гадуур хувцас, кабелийн телевизийн хураамж, шатахууны үнэ 0,1-40,0 хувиар өссөн байна.

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 19,3 хувийнх нь буюу 46 нэрийн бараа үйлчилгээний үнэ буурч, 39,5 хувийнх нь буюу 94 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 41,2 хувийнх нь үнэ тогтвортой байна.


Өнгөрсөн оны мөн үеийнхээс үхэр, ямааны мах, байцаа манжин, сонгино, сармис, шар будаа зэргийн үнэ 0,1-38,8 хувиар буурч харин адууны мах, цагаан будаа, тараг, шар тос, өндөг, амтлагч, гуанзны хоолны үнэ, эрэгтэй эмэгтэй хүний гадуур, дотуур хувцас, гутал, ботинк, саван, хадаас, мотоцикл, бүх төрлийн шатахуун, кабелийн телевизийн хураамж зэрэг барааны үнэ 0,2- 75,0 хувиар нэмэгдсэн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

10 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 80,8 хувь нь буюу 1794,1 мянган эх мал төллөж гарсан төлийн 93,1 хувь нь буюу 1669,9 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 88,9 хувь, унаганы 93,1 хувь, тугалын 94,1 хувь хурганы 94,4 хувь, ишигний 89,7 хувь нь бойжиж байна.

Сумдаас Чулуут, Төвшрүүлэх, Жаргалант, Тариат сумд гарсан төлөө 97,2 – 98,8 хувиар бойжуулж байна.




Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төллөсөн эх мал 3,9 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 6,8 хувиар бага, төлийн хорогдол 65,9 хувиар их байна.

Оны эхний мал 94,3 хувиар онд орж оны эхний малын 5,7 хувь буюу 299,5 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 10,3 хувийг адуу, 18,9 хувийг үхэр, 40,6 хувийг хонь, 30,2 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Сумдаас Хотонт, Цэнхэр, Өгийнуур, Хашаат, Өлзийт, Батцэнгэл сумдын оны эхний малын 6,9- 13,6 хувь нь, Цахир, Хайрхан, Ихтамир, Төвшрүүлэх, Булган, Өндөрүлаан, Хангай, Эрдэнэбулган сумдын оны эхний малын 3,0- 5,5 хувь нь, бусад сумдын малын 0,3-2,7 хувь нь хорогдсон дүнтэй байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



Энэ хавар 6913,1 га-д үр тариа, 252,0 га-д төмс, 104,6 га-д хүнсний ногоо, 1466,8 га-д малын тэжээлийн ургамал, 1178 га-д техникийн ургамал тус тус тариалаад байна.

Өнгөрсөн оны энэ үеийнхтэй зэрэгцүүлэхэд үр тариа 10,3 хувиар, төмс 47,4 хувиар, техникийн ургамал 15,8 хувиар, хүнсний ногоо 39,2 хувиар, тэжээлийн ургамал 19,9 хувиар тус тус бага тариалсан байна.

10 дугаар сарын 1-ний байдлаар аймгийн дүнгээр үр тариа 1990,5 тн, төмс 2098,3 тн, хүнсний ногоо 466,2 тн, тэжээлийн ургамал 2081,6 тн, техникийн ургамал 21 тонныг хурааж, байгалийн хадлан 67,3 мянган тн, гар тэжээл 811,6 тонныг бэлтгээд байна.

2018 онд манай аймаг ойгоос 96,6 мянган м3 галын түлээ, 11,1 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 107,7 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 9 сард 38,2 мянган м3 галын түлээ, 8,2 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 46,4 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 157,4 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.




АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2018 оны эхний 9 сард оны үнээр 4237,4 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан нь өнгөрсөн оныхоос 7,5 хувиар их байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 1391,4 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1,2 хувиар их байна.

Нийт үйлдвэрлэлтийн 12,3 хувийг хүнс ундааны, 1,3 хувийг хэвлэлийн, 53,0 хувийг дулааны эрчим хүчний, 16,8 хувийг усан хангамж, 4,8 хувийг модон эдлэлийн, 6,6 хувийг гутал хувцасны, 5,2 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, савласан цэвэр ус, дулаан, зүсмэл, хүснэгт маягт, монгол гутлын үйлдвэрлэл 0,5- 46,0 хувиар нэмэгдлээ. Харин бууз, хиам, монгол дээл, хүрмэн блокны үйлдвэрлэлийн хэмжээ 7,1 – 54,0 хувиар буурсан байна.



Оны эхний 9 сард барилгын байгууллагууд 5171,7 сая төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийсний 90,0 хувь нь угсралтын ажил байна.

Тээврийн байгууллагууд 31,2 мянган зорчигч, 22,7 мянган тонн ачаа тээвэрлэн 14,5 сая хүн км, 2,2 сая ткм ажил гүйцэтгэн 288,8 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлт, ачаа, эргэлтийн хэмжээ 8,5 -158,4 хувиар нэмэгдлээ.

Холбооны байгууллагууд 406 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 177,6 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 0,4 хувиар буурсан байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

9 дүгээр сард агаарын дундаж температур 3,9-аас 9,6 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Хашаат, Хотонт, Өлзийт, Өгийнуур, Хайрхан сумдад 23,0-26,0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Чулуут, Тариат, Өндөрүлаан, Хангай сумдад -8,0-оос -11,0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Энэ сард Цахир, Булган, Төвшрүүлэх, Хотонт, сумдын нутгаар 61,1 – 67,7 мм хур тундас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Цэцэрлэг, Батцэнгэл, Эрдэнэмандал сумдад 2,1 – 21,8 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

Статистикийн хэлтэс
2018.10.10